

## **ЗАХИРЛЫН МЭДЭЭЛЭЛ**

### **Жилийн Ерөнхий Хуралдааны талаар**

ОУДС-ийн жилийн ерөнхий хуралдаан 10 сарын 8-ны Пүрэв гарагт сургууль дээр 19:00 цагт болно. 18:00 цагаас санхүүгийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл сонирхсон хүмүүст зориулж товч хурал хийнэ. 10 сарын 8-ны орой та бүхэн хүрэлцэн ирж хуралдаа оролцоно гэдэгт миний бие болон сургуулийн Удирдах Зөвлөлийн хамт олон итгэлтэй байна. Удирдах Зөвлөлд сонгогдохоор нэрээ дэвшүүлсэн эцэг эхчүүдийн талаарх мэдээллийг та бүхэнд удахгүй хүргэх болно. Энэ мэдээллийг хүлээж аваад сайтар уншиж танилцаарай. Бид санхүүгийн товч тайланг электрон шуудангаар эцэг эхчүүдэд хүргэх болно. Та бүхэн хуралд биеэр ирж чадахгүй бол Мэдээнд хавсаргасан хуудсыг бөглөж таныг төлөөлөн санал өгөх хүнийг сонгоорой.

Эцэг эхчүүд та нар Жилийн Ерөнхий Хуралдаанд хүрэлцэн ирсэнээр хүүхэддээ 5 house point авч өгөх боломжтой. Та бүхэн хуралд ирж оролцох буюу таныг төлөөлөн санал өгөх хүнийг томилох нь чухал. Зөвлөлийн дүрэмд зааснаар нийт гишүүдийн 25 хувь буюу 72 эцэг эх хуралд оролцож байж хурал хүчин төгөлдөр болж санал хураах эрхтэй. Хурлын үеэр бид та бүхэнд оройн хоолоор үйлчилнэ.

### **Сургууль дээр Сувилагч ажиллана**

10 сарын 1-нээс эхлэн сургууль дээр англи, монгол хэлтэй сувилагч 9:45-16:00 цаг хүртэл ажиллана. Сурагчдын завсарлагаа, үдийн цайны цаг, дугуйлангийн цагуудаар сургууль дээр сувилагч ажиллана. Сургууль дээр анхны тусламж үзүүлэх хэрэгцээ элбэг тохиолдож байгаа нь ажиглагдсан. Хэдийгээр эмчийн үүрэг гүйцэтгэхгүй ч гэсэн мэргэжлийн сувилагч ажилласнаар сурагчдад анхны тусламж үзүүлэх боломжтой болж байгаа юм.

### **МАР (Сурлагын Түвшин Тогтоох Шалгуур)**

Сурагчдын мэдлэг чадварын түвшин тогтоох энэ шалгуур нь сурагч нэг бүрийнхээ сурах арга барил, чадварт нийцүүлэн сургалтаа явуулах боломжийг багш нарт олгодог юм. Бид энэ шалгуурыг Дунд болон Бага сургуулийн хэмжээнд хэрэгжүүлж эхлээд байна. Энэ шалгуурын хүрээнд сурагчдын математик, унших чадвар, хэлний мэдлэгийн түвшинг тогтоох болно.

### **Эцэг Эх Багш нарын Зөвлөл**

ЭБЗ-ийн хурал 9 сарын 29-ний Мягмар гарагт 15:00 цагт Номын Санд болно. Та бүхэн хүрэлцэн ирж хуралд оролцоорой.

### **Автобусаар зөв боловсон үйлчлүүлэх талаар**

Автобусанд сурагчид бие биенээ дээрэлхэж, таагүй байдал гаргадаг талаар бидэнд мэдээлэл ирсэн. Мөн аюулгүй байдлыг зөрчсөн үйлдэл гарсан байна. Сурагчдын зүгээс ийм асуудлууд гаргахыг бид зөвшөөрөхгүй. Та бүхэн автобусаар явах, гадаа тоглох, хичээлээс гадуур зохиогдож буй арга хэмжээний үеэр биеэ хэрхэн зөв авч явах талаар хүүхдүүдтэйгээ ярилцаарай. Бид бүх сурагчдынхаа төлөө аюулгүй, тав тухтай орчинг бүрдүүлэхэд анхаарч ажилладаг. Хэрвээ хүүхдийн аюулгүй байдал хангагдахгүй бол тэд сайн суралцаж чадахгүй. Сурагчийн нэг өдөр автобусанд сууж сургуулийн үүдэнд ирэхээс эхэлдэг. Тиймээс хичээлийн нэг өдрөө амжилттай эхлэхэд нь хүүхдүүддээ туслаарай.

Бид сурагчдыг аль болох хурдан хугацаанд аваар осолгүй хичээлд нь ирүүлэхэд анхаарч автобусны хуваарийг төлөвлөж хийдэг. Хэрвээ сурагчид цагтаа гарч ирэхгүй жолоочийг хүлээлгэвэл бид зорилгодоо хүрч чадахгүй. Иймээс сурагч нэг бүр цагтаа хоцролгүй зогсоол дээрээ байх нь чухал.

Жолооч нарт бид цагийн хуваарийг нарийн баримтлах үүрэг өгсөн. Хүүхэд тань цагаасаа хоцорвол та бүхэн өөрсдөө хүргэх шаардлага гарах бөгөөд нийт хүүхдийг цагт нь сургуульд хүргэхийн тулд бид энэ арга хэмжээг авах шаардлагатай байна.

### **Машины Зогсоолын аюулгүй байдал**

Манай машины зогсоолд машинаа зөв байрлуулж байгаад бид та бүхэнд болон жолооч нарт тань талархал илэрхийлье. Машинаа зогсоолд зөв байрлуулсанаар бид багш, сурагчид, эцэг эхчүүд та бүхний аюулгүй байдлыг хангаж чадна. Та бүхэн сургуулийн орчин тойронд болон машины зогсоолоос хөдлөхдөө хурдаа сааруулж яваарай. Бага насны хүүхдүүд заримдаа харагдахгүй харин том хүүхдүүд нь өөрсдөө заримдаа анхааралгүй явах тал байдаг.

### **Цаг Агаарын талаар**

Цаг агаар хүйтэрч эхэлж байгаа тул хүүхдүүдээ хичээлд нь дулаан хувцаслаж явуулаарай. Бид сурагчдаа өвдүүлэхгүй байх тал дээр анхаарч ажиллана.

Та бүхний ирэх долоо хоногийн ажилд амжилт хүсье.

**Захирал Greg Rayl**

### **СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛӨӨС**

*Эрхэм Хүндэт Эцэг Эхчүүд ээ,*

*ОУДС-ийн Удирдах Зөвлөлийн гишүүдийн өмнөөс би та бүхэнд шинэ хичээлийн жилийн мэнд хүргэе! Манай Жилийн Ерөнхий Хуралдаан 2009 оны 10 сарын 8-ны Пүрэв гарагт 19 цагт болно. Энэ жилийн ерөнхий хуралдаан нь ОУДС-ийн хамт олон бидэнд олсон ололт амжилтаа дүгнэж ирээдүйгээ төлөвлөх сайхан боломжийг олгодог юм. Энэ хуралдаанаар Сургуулийн Удирдах Зөвлөлийн шинэ гишүүдийн сонгууль явагддаг. Удирдах Зөвлөлийн гишүүд 2 жилийн хугацаатай сонгогддог. ОУДС-ийн сурагчдын бүх эцэг эхчүүд (тус сургуульд ажилладаг эцэг эхчүүд сонгуульд оролцохгүй) болон сурагчдын хууль ёсны асран хамгаалагчид энэ сонгуульд оролцож сургуулийг удирдах үйлчлэлд хувь нэмрээ оруулах боломжтой.*

*Хэрвээ та бүхэн Жилийн Ерөнхий Хуралдаанд оролцох боломжгүй бол таныг төлөөлж санал өгөх хүн томилж байгаа тухайгаа бичгээр бөглөж сургуулийн Ресепшинд авчирч өгөх буюу 10 сарын 8-нд хуралд оролцох эцэг эхээр дамжуулж өгч болно. Энэ хуудсыг бид Мэдээнд хавсаргасан болно.*

*Та бүхнийг хүндэтгэсэн*

*ОУДС-ийн Удирдах Зөвлөлийн Дарга*

*Shane Rosenthal*

*shane.rosenthal@gmail.com*

### **ДУНД СУРГУУЛИЙН МЭДЭЭ**

Дунд сургуулийн хамт олон бид энэ долоо хоногийг амжилттай дуусгаж байна. Манай 5 багш ОУББ-ын мэргэжил дээшлүүлэх сургалтанд оролцоод ирлээ. Тэд буцаж ирээд өөрсдийн сурсан зүйлс болон бүсийн сургуулиудын мэргэжил нэгтнүүдтэйгээ уулзаж санал солилцох боломжтой болсон тухайгаа бидэнтэй хуваалцсан. Манай сургууль багш нараа сургалтанд тогтмол

хамруулсанаар эргээд багш нар маань сурагчиддаа өндөр түвшинд сургалт явуулах боломжийг бид тэдэнд олгож байгаа юм.

Дунд сургуулийн сурагчдын дунд хөл бөмбөгийн тэмцээн явагдаж эхэллээ. Өнгөрсөн Бямба гарагт хөвгүүдийн багийн тэмцээн зохиогдсон бөгөөд энэ Бямба гарагт охидын багийн тэмцээн болно. Сурагчдын Зөвлөл өнөө орой 6-8-р ангийн сурагчдад кино үзүүлнэ. Та бүхэн хүүхдүүдээ энэ арга хэмжээнд оролцуулаарай. Тэд 2 киноноос сонголтоо хийж үзэх боломжтой.

Цаг агаар хүйтэрч өвлийн улирал удахгүй эхлэх гэж байна. Хүүхдүүдээ дулаан хувцаслаж, ус ууж сайн унтаж амрахад нь туслаарай. Бид сурагчдаа өвдүүлэхгүй тал дээр хичээж ажиллах болно. Та бүхэн амралтын өдрүүдээ сайхан өнгөрүүлээрэй. Кино үзвэрийн үеэр та бүхэнтэй уулзана гэж найдаж байна.

**Дунд Сургуулийн Эрхлэгч  
Betsy Hanselmann**

### **МҮР буюу Дунд Сургуулийн Хөтөлбөрийн талаар**

10 сарын 1-ны Пүрэв гарагт орой 7-8 цагийн хооронд сургуулийн номын санд бүх эцэг эхчүүдэд зориулж МҮР хөтөлбөрийн талаар мэдээлэл хийнэ. Та бүхэн энэ үеэр дараах асуултнуудад хариулт авах болно:

Хичээлийн сэдэв, агуулгыг бодит амьдралтай хэрхэн уялдуулах вэ?

Манай хүүхдийн мэдлэгийн түвшинг хэрхэн үнэлэх вэ?

МҮР хөтөлбөр нь сурагчдыг дипломын хөтөлбөр судлахад хэрхэн бэлтгэдэг вэ?

Personal Project буюу Бие дааж гүйцэтгэх төслийн ажил гэж юу вэ?

Та энэ уулзалтанд оролцох эсэхээ [d.chilton@isumongolia.edu.mn](mailto:d.chilton@isumongolia.edu.mn) хаягаар бидэнд мэдэгдэнэ үү.

**МҮР хөтөлбөрийн Зохицуулагч, David Chilton**

### **Сурагчдын Зөвлөлөөс**

10 сар удахгүй болох гэж байна. Ирэх долоо хоногийн Баасан гараг 10 сарын 1. Сурагчдын Зөвлөл энэ өдрийг унтлагын хувцасны өдөр болгож тэмдэглэх гэж байна. Багш сурагчид та бүхэн энэ өдөр хичээлдээ унтлагын хувцастайгаа ирж болно. Гэхдээ Хувцаслах дүрмийг бас анхаарахад илүүдэхгүй. Та бүхэн Сурагчдын Зөвлөлөөс зохиож байгаа арга хэмжээнд идэвхтэй оролцоорой.

## **БАГА СУРГУУЛИЙН МЭДЭЭ**

### **Хичээлээс гадуур зохиогдсон аялалууд**

4-р ангийн сурагчид Дэлхийн Шашнууд сэдвийн хүрээнд хэд хэдэн сүм хийдээр зочилж бас шашны төлөөлөгчдийг ангидаа урьж ярилцлага хийлээ. Бидний урилгыг хүлээн авч бидэнд өөрсдийн итгэл үнэмшил, шашны зан үйлийн талаар хуваалцсан зочиддоо талархал илэрхийлье.

2-р ангийн сурагчид хайрцаг ашиглан байшин барьж байгаа бөгөөд энэ долоо хоногт тэд Баян Монгол хороололд зочилж айлууд гэрээ хэрхэн тохижуулдагийг үзэж сонирхлоо.

5-р ангийн сурагчид өнгөрсөн долоо хоногт Баян Зүрх дүүргийн гэр хороололд зочилж тэдэнд хэрхэн туслах талаар төсөл боловсруулах ажилдаа ороод байна. Намрын баярын үеэр цуглуулсан хандивыг юунд зарцуулах тал дээр шийдвэр гаргахад тэд оролцох юм. Тэд өөрсдийн төслийг ЭБЗ-ийн дараагийн хуралд хэлэлцүүлэхээр бэлтгэж байна.

### **Өдөрлөг**

Энэ 7 хоногт бага сургуулийн өдөрлөг дээр тоглолтоо сонирхуулсан 3-р ангийн багш сурагчиддаа баярлалаа. Тэд хэд хэдэн зөрчилтэй асуудлуудаар жүжигчилсэн тоглолт хийж зөрчлийг хэрхэн шийдэх тал дээр үзэгчдээс зөвлөлгөө хүслээ.

## **Зургийн тэнхим**

Хэрвээ та бүхний гэрт хуучин сонин сэтгүүлүүд байгаа бол манай зургийн тэнхимд авчирч өгч house point цуглуулах боломжтой.

## **БИЕИЙН ТАМИРЫН ТЭНХМЭЭС**

### **Волейболын багийн бэлтгэл**

Энэ жил АСАМIS волейболын тэмцээн 10 сарын 29-нээс эхлэн БНХАУ-ын Нинбо хотноо болно. Энэ тэмцээнд оролцох манай баг тамирчид бэлтгэлээ хийж эхэллээ. Одоогийн байдлаар тэмцээнд оролцох сурагчдыг сонгож дууссан боловч багт ороогүй сурагчид үргэлжлүүлэн бэлтгэлд оролцох хэрэгтэй. Бэлтгэл хийх хуваарь:

Охидын баг: Мягмар, Пүрэв гарагуудад 4.00-5.30

Хөвгүүдийн баг: Лхагва гарагт 4.00-5.30, Бямба гарагт 1.00-3.00

### **Сургууль дээр зохиогдох тэмцээнүүд**

6-8-р ангийн хөвгүүдийн хөл бөмбөгийн тэмцээн амжилттай болж өнгөрлөө. Цэнхэр багийн тамирчид тэмцээнийг хошуучилсан. 20 гаруй сурагчид энэ жилийн тэмцээнд оролцлоо. Багаа сайн зохион байгуулж тамирчин бүрт тоглох боломж олгосон багийн ахлагч нарт (Kristian, Пүрэвбат, Mathias, Мишээл) баяр хүргэе.

Багуудын оноог мэдээний англи хувиас харна уу.

Гоол оруулсан тамирчид:

Mathias-4(Улаан баг), Kristian-3 (Цэнхэр баг), Justin-3 (Цэнхэр баг), Мишээл-2 (Шар баг), Jung Hyung (Шар баг), Joseph-1 (Цэнхэр баг), Пүрэвбат (Ногоон), Sameen-1 (Ногоон), Цэцэ (Ногоон)

Энэ Бямба гарагт охидын багийн хөл бөмбөгийн тэмцээн болно. Охидын багийн ахлагчид:

Цэнхэр багийн ахлагч-Tiffany

Ногоон багийн ахлагч-Nathalie

Улаан багийн ахлагч-Teresa

Шар багийн ахлагч-Пүрэвсүрэн

Тоглогч тус бүр багийнхаа өнгөтэй футболка өмсөнө. Тэмцээн өглөө занд 10 цагаас эхэлж 2 цаг үргэлжилнэ. Тэмцээнд оролцсон сурагчдыг 12 цагт ирж авах хэрэгтэй. Хөгжөөн дэмжигчид та бүхэн ирж тэмцээн үзээрэй. 10 сарын 3-ны Бямба гарагт 9-12-р ангийн охидын багийн волейболын тэмцээн болно.

**Биеийн Тамирын Тэнхмийн Эрхлэгч**

**David Ricketts**